

## ИННОВАЦЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилто т түвшин	Хүрсэн түвшин / Биелэлт	Хугацаа (I-IV улирал)	Гүйцэтгэлийн хувь
<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1. ХАРИЛЦАА ХОЛБОО, ИННОВАЦ, ГАРААНЫ БИЗНЕС, ИХ ӨГӨГДӨЛ, ХИЙМЭЛ ОЮУН УХААН, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН, ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ, РАДИО ДАВТАМЖ, САНСРЫН ТЕХНОЛОГИ, КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ХУУЛЬ ТОГТООМЖ, СТАНДАРТ, ДҮРЭМ, ЖУРАМ, УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ШААРДАГДАХ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН УЯЛДААГ ХАНГАХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ</b>							
	<b>Зорилт 1. Инновац, гарааны бизнес, их өгөгдөл, хиймэл оюуны хөгжлийн бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангана.</b>	<b>Судалгааны тоо Хүргүүлсэн хуулийн төслийн тоо</b>	<b>0 0</b>	<b>1 1</b>	<b>Судалгааны тоо 0 Хүргүүлсэн хуулийн төслийн тоо 0</b>		
1.	Арга хэмжээ 1.1. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх, хуулийн төсөл	Судалгааны тоо Хүргүүлсэн хуулийн төслийн тоо	0 0	1 1	Тус яамны сайдын 2025 оны A/49 дүгээр тушаалаар "Дроны ашиглалт, хэрэглээний талаар судалж, хууль эрх зүйн орчны судалгаа хийж санал боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, эхний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр цахимаар зохион байгуулсан.  Уг хурлаар тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах" ажлын	II-III улирал	50

	боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.				даалгаврын төслийг танилцуулан, ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналыг тусган эцэслэж, батлуулсан.		
СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ТӨРӨӨС ИРГЭДЭД ҮЗҮҮЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭГ ДАХИН ИНЖЕНЕРЧЛЭЛ ХИЙХ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН, ШУУРХАЙ, ЧИРЭГДЭЛГҮЙ ХҮРГЭХЭД ЧИГЛҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ							
Зорилт 2. Төрийн байгууллагуудын мэдээллийн сан, мэдээллийн систем, нээлттэй өгөгдлийг уялдуулах, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тогтолцоо, нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, зохион байгуулах, зохицуулах	Төслийн саналын тоо	0	1	Төслийн саналын тоо 0			
2. Арга хэмжээ 2.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр ногоон дата төв байгуулах төслийн санал боловсруулна.	Төслийн саналын тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй. Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төсөлд дата төв байгуулах арга хэмжээг оруулж, холбогдох тооцооллыг эхний байдлаар гаргасан.	I-IV улирал		

	Зорилт 3. Нийгэм, эдийн засгийг инновац шингэсэн технологиор хөгжүүлэх, инновац шингэсэн технологиудыг нутагшуулах, турших, инновацийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах	Судалгааны тоо Хүргүүлсэн баримт бичгийн тоо Боловсруулсан баримт бичгийн тоо Тавигдах шаардлагын тоо Арга хэмжээний тоо Сургалтын тоо Гарын авлагын тоо Нэр томъёоны лавлахын тоо Хөтөлбөрийн тоо	0 0 0 0 0 0 0 0	4 2 3 1 7 1 1 1	Судалгааны тоо 1 Хүргүүлсэн баримт бичгийн тоо 1 Боловсруулсан баримт бичгийн тоо 1 Тавигдах шаардлагын тоо 0 Арга хэмжээний тоо 3 Сургалтын тоо 1 Гарын авлагын тоо 0 Нэр томъёоны лавлахын тоо 1 Хөтөлбөрийн тоо 0		
3.	Арга хэмжээ 3.1. “Шинэ Хархорум” хотын “Орхон хөндий”-д ёндөр технологи, инновац, бизнес хөгжлийн төв байгуулах судалгаа хийнэ.	Судалгааны тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	IV улирал	-
4.	Арга хэмжээ 3.2. Инновацийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлын даалгаврыг боловсруулан баталгаажуулсан. Тус ажлыг Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнгээс хийж гүйцэтгэн, үнэлгээний тайланг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Инновац, цахим бодлогын байнгын хороонд хүргүүлсэн.	Судалгааны тоо	0	1		I-II улирал	100

5.	Арга хэмжээ 3.3. Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	II-III улирал	-
6.	Арга хэмжээ 3.4. Инновац, мэдээллийн технологийн паркийн талаар судалгаа хийж, цаашид баримтлах бодлогыг боловсруулж, бус, орон нутагт парк байгуулахад тавигдах шаардлагыг тодорхойлно.	Боловсруулсан баримт бичгийн тоо  Тавигдах шаардлагын тоо	0  0	1  1	<p>Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд бус орон нутагт өндөр технологи, инновацийг нэвтрүүлнэ зорилтын хүрээнд “Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффис байгуулах ТЭЗҮ, зураг төслийн ажил хийж гүйцэтгэх” ажлын хүрээнд мэдээллийн технологийн хаб/хамтын оффисыг бус болгонд байгуулахтай холбоотой судалгааны эхлэлийн тайланг хүлээн авх танилцсан. Судалгаанд үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А/80 дугаар тушаалаар уг хабуудыг байгуулах бүсийн байршлыг тогтоосон.</p> <p>Дээрх тогтоосон байршуудыг Засаг дарга нартай холбогдон ажиллаж, хаб байгуулах нөхцөл шаардлага, эскиз зургийг боловсруулж байна.</p>	II-IV улирал	90
7.	Арга хэмжээ 3.5. Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын болон тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн төслийн тоо	0	1	“Инновацийн төслийг улсын төсвөөс санхүүжкуулэх, инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 01/832 дугаартай албан бичгээр Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга нараас санал авахаар хүргүүлсэн. Засгийн газрын гишүүдээс нийт 20 санал ирснийг нэгтгэн, журмыг эцэслэж Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр 2025 оны 05 дүгээр сарын 01-ний өдрийн 01/1029 дугаартай албан бичгийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Тус тогтоолын төсөл нь Засгийн газрын 2025 оны 05 дүгээр сарын 07-ны өдрийн 224 дугаар тогтоолоор батлагдсан.	I улирал	100

8.	Арга хэмжээ 3.6. "ICT экспо 2025" арга хэмжээг зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	0	1	<p>Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, төрийн болон салбарын хувийн хэвшлийн байгууллагуудын дунд салбар хэлэлцүүлэг, "ICT EXPO-2025" үзэсгэлэнг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Сайдын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн A/38 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд уг ажлын хурлаар тус арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөсөн.</p> <p>Үүний дагуу тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "ICT ЭКСПО 2025" ЦХИХХЯ/20250103113 дугаартай арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны A/113 дугаар тушаалаар байгуулж, тендер шалгаруулалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулан 06 дугаар сарын 03-ны өдөр тендерийг нээгээд байна.</p>	II улирал	70
9.	Арга хэмжээ 3.7. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж буюу дрон жолоодлогын Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	0	1	<p>Тайлант хугацаа болоогүй.</p> <p>Мөн тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны A/01 дугаар тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан "Дрон жолоодлогын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах" ажлын даалгаврыг боловсруулан, батлуулсан.</p>	IV улирал	-
10.	Арга хэмжээ 3.8. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн сургалт зохион байгуулна.	Сургалтын тоо	0	1	"Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн сургалт зохион байгуулах" ЦХИХХЯ/20250603127 дугаартай үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай 2025 оны 02 дугаар сарын 17-ний A/37 дугаартай тушаалын дагуу 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр "Дижиталсервис" ХХК-тай Г/04 дугаартай гэрээг байгуулан 2025 оны 02 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд сургалтыг амжилттай зохион байгуулсан.	I-II улирал	100

						Tус сургалт нь дроны талаарх онолын мэдлэг, техникийн бэлтгэл, нислэгийн дадлага гэсэн үндсэн турван хэсгээс бүрдсэн бөгөөд дроны бүтэц, нислэгийн үндсэн зарчим, аюулгүй ажиллагааны дүрэм гэсэн сэдвүүдээр нийт 8 цагийн сургалтыг Хонхорын радио нэвтрүүлэх төв станцын байршилд хийсэн. Сургалтад оролцогчид нислэгийн дадлага хийж, автомат болон гараар удирдах техникиг туршин үзсэн бөгөөд анхан шатны оролцогчид дрон хөөргөх, буулгах, энгийн зураг авахад харин дунд шатны оролцогчид илүү нарийн маршрутын дагуу бартаат нислэг үйлдэж, салхины нэхцэлд тэнцвэр хадгалах, тусгай зорилгоор бичлэг хийх зэрэг чадварыг эзэмшүүлсэн.		
11.	Арга хэмжээ 3.9. Дрон жолоодлогын сургалтын хөтөлбөр боловсруулах, шалгалт баталгаажуулалтын гарын авлага боловсруулна.	Гарын авлагын тоо	0	1		<p>Тус яамны сайдын 2025 оны А/47 дугаар тушаалаар “Сургалтын тогтолцоо бий болгох, зэрэг дэв олгох, санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, эхний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр цахимаар зохион байгуулсан.</p> <p>Уг хурлаар тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/01 дугаар тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Дроны жолоодлогын сургалт хөтөлбөр боловсруулах, шалгалт баталгаажуулалтын гарын авлага боловсруулах” ажлын даалгаврын төслийг танилцуулан, ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналыг тусган эцэслэж, батлуулсан.</p> <p>Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/98 дугаар тушаалаар байгуулсан. Уг тендерийг 2025 оны 4 дүгээр сарын 22-нд зарласан боловч амжилтгүй болсон тул дахин 2025 оны 5 дугаар сарын 5-нд зарлан үнэлж, МУИС-ийн Бизнесийн сургуультай 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдөр гэрээг байгуулсан.</p>	I-III улирал	70

12.	Арга хэмжээ 3.10. Дэвшилтэт технологийн нэр томьёоны лавлах гаргана.	Нэр томьёоны лавлахын тоо	0	1	Дэвшилтэт технологийн нэр томьёоны лавлах гаргах ажлыг "Системийн инженерчлэлийн институт" ГҮТББ-тай 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Y/14 дүгээр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.	I-III улирал	100
13.	Арга хэмжээ 3.11. Монгол Улсын инновацийн тогтолцооны гүйцэтгэлийг олон судалгааны аргачлалыг нутагшуулж, мэдээллийн технологийн болон өндөр технологийн салбарт инновацийн судалгаа хийнэ.	Унэлэх улсын унэлэх улсын Судалгааны тоо	0	1	"Монгол улсын инновацийн тогтолцооны гүйцэтгэлийг үнэлэх олон улсын судалгааны аргачлалыг нутагшуулж, мэдээллийн технологийн болон өндөр технологийн салбарт инновацийн судалгаа хийх" ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан.  Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/133 дугаар тушаалаар байгуулсан.	I-II улирал	40
14.	Арга хэмжээ 3.12. Шилдэг инновацийн төсөл шалгаруулах хөтөлбөрийг орон даяар зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	0	1	"Инновацийн төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх журам"-ын 3.5-д заасан "Инновацийн бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журам"-ын төслийг боловсруулан хуулийн хэлтсээс санал авахаар хүргүүлсэн. Журмын төсөл хянуулах шатандаа явж байна.  Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтооолоор батлагдсан "Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1-т заасны дагуу инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох сонгон шалгаруулалт зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг, ажлын хэсгийн удирдамжийг боловсруулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн тушаалаар батлуулсан.	I-IV улирал	70

15.	Арга хэмжээ 3.13. Электроник, автоматжуулалтын салбарын бодлогын судалгаа хийх, стратеги боловсруулна.	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	1	<p>“Электроникс, автоматжуулалтын салбарын бодлогын судалгаа хийх, стратеги боловсруулах” ЦХИХХЯ/20250603079 дугаартай үйлчилгээний шууд худалдан авалтын ажлыг зохион байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/132 дугаартай гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай тушаалыг гаргуулж, 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Хүрээ санал шийдэл” ХХК-тай байгуулсан Y/13 дугаартай гэрээний дагуу ажлын явцын тайланг хүлээн авсан.</p> <p>Энэхүү тайлан нь Монгол улсын электроникийн салбарыг хөгжүүлэх нарийвчилсан замын зургийг 2025-2030 он хүртэл тодорхойлж, одоогийн сорилтуудыг шийдвэрлэх, стратегийн боломжуудыг ашиглах замаар эдийн засаг, технологи, нийгмийн хөгжилд томоохон ахиц авчирна. Хэрэв амжилттай хэрэгжвэл Монгол Улс дэлхийн электроникийн зах зээлд тогтвортой байр суурь эзэлж, технологийн тэргүүлэгч орнуудын нэг болох боломжтой.</p>	I-IV улирал	90
16.	Арга хэмжээ 3.14. Инновацийн шинэ санааг хөгжүүлэх бүх насны иргэдэд зориулсан 10 цуврал контент хийнэ.	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	1	<p>“Инновацлаг санааг хөгжүүлэх бүх насны иргэдэд зориулсан 10 цуврал бичлэг, нэвтрүүлэг, материал бүтээх” ЦХИХХЯ/20250103089 дугаартай тендер шалгаруулалтыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/112 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 05 дугаар сарын 05-ны өдөр цахим системд нийтлэн зарласан.</p> <p>Тендерийг 05 дугаар сарын 26-ны өдөр нээхэд оролцогчгүй байсан тул 05 дугаар сарын 29-ний өдөр дахин зарласан бөгөөд 06 дугаар сарын 19-ний өдөр нээж, үнэлэх юм.</p>	I-IV улирал	90

17.	Арга хэмжээ 3.15. Салбарын мэргэшсэн мэргэжилтнүүдийг практик мэдлэг мэдээллийг оюутнуудад заах боловсруулах, судалгаа хийнэ.	Судалгааны тоо	0	1	"Салбарын мэргэшсэн мэргэжилтнүүдийг практик мэдлэг мэдээллийг оюутнуудад заах боломжийг бүрдүүлж цагийн багш хөтөлбөр боловсруулах, судалгаа хийх" ЦХИХХЯ/20250203090 үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/139 дугаартай тушаалаар байгуулсан. Тус үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн сайн тендер ирүүлсэн "Дийг Ай Ти" ХХК руу гэрээ байгуулах мэдэгдлийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр хүргүүлж, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр гэрээ байгуулан төлөвлөгөөт хуваарийн дагуу ажиллаж байна.	I-IV улирал	80
18.	Арга хэмжээ 3.16. Салбарын судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээг хангах, тэдний чанарыг сайжруулах зорилгоор цалинтай PhD доктор хөтөлбөрийг боловсруулна.	Хөтөлбөрийн тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	I-IV улирал	-
19.	Арга хэмжээ 3.17. Мэдээллийн технологийн ажилтан, албан хаагчдын мэдлэг, мэдээллээ солилцох, шинэ технологи, инновацтай танилцах боловсруулах, Мэдээллийн технологийн ажилтны өдөрлөгийг зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	III улирал	-

20.	Арга хэмжээ 3.18. “Цахим хөгжил, инновац, холбооны 2025” зөвлөгөөн байгуулна.	Арга хэмжээний тоо	0	1	<p>Зүүн бүсийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, бус нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, эдийн засаг, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд цахим технологийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох, зүүн бус нутагт ажиллаж байгаа салбарын мэргэжилтэн, албан хаагчдын санал санаачилгыг дэмжих, санал хүсэлтийг бодлого, арга хэмжээнд тусган ажиллах зорилгоор “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын зүүн бүсийн чуулга уулзалт”-ыг Хэntий аймгийн төв Чингис хотод 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Чуулганаар зүүн бүсэд тулгарч буй нийгмийн асуудлыг дижитал технологи нэвтрүүлэн шийдвэрлэх, орон нутгийн бизнест дижитал шийдлийг нэвтрүүлэх, орон нутгийн гарааны бизнесийг хөгжүүлэх зэрэг асуудлаар форум хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус чуулга уулзалтыг зохион байгуулах бэлтгэл ажилтай холбоотойгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын нэгдсэн чуулга уулзалтыг Хэntий аймгийн төв Чингис хотод зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн A/44 дугаар тушаалаар байгуулсан.</li> <li>Ажлын хэсгийн хурлын нийт 5 удаа хуралдуулж, ажлын хэсгийн гишүүдэд ажил үүргийг хуваарилан хэрэгжүүлсэн.</li> <li>Чуулганы илтгэл, үйл ажиллагааны зохион байгуулалтын хүрээнд Сайд, Төрийн нарийн бичгийн даргын хэлэх уг, илтгэл бэлтгэх, модератор болон панелистуудад мэдээлэл өгөх, протокол хөтлөх, шагнал гардуулах үйл ажиллагаа гэх мэт;</li> <li>Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа, үзэсгэлэнд оролцох хотын болон орон нутгийн байгууллагуудыг зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</li> </ul>	I-II улирал	100

					Mөн чуулганы үеэр "Мэдээллийн технологийн төрөлжсөн төв байгуулах", "Зүүн бүсийн логистикийн төв байгуулах" санамж бичгүүд зурагдаж, зүүн бүсийн 45 суманд төрийн үйлчилгээний КИОСК машиныг гардуулах, Хиймэл Оюуны илч "1000 AI Ambassador" хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан.			
21.	Арга хэмжээ 3.19. Бүсчилсэн хөгжлийн цахим сургалт хэлэлцүүлэг зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	0	1	"Бүсчилсэн хөгжлийн цахим сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах" ЦХИХХЯ/20250603124 дугаартай үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/53 дугаартай тушаалын дагуу "Норт шүр" ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Y/02 дугаартай гэрээ байгуулсан. Арга хэмжээний хөтөлбөрийн дагуу 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр 4 сэдвийн хүрээнд сургалт хийгдсэн бөгөөд 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр 3 сэдвийн хүрээнд сургалт явуулсны дараа хэлэлцүүлгийг танхимаар 250, цахимаар 200 гаруй оролцогчдын дунд зохион байгуулж, санал солилцсон.	II улирал	100	
22.	Арга хэмжээ 3.20. Мэдээлэл технологийн олимпиад зохион байгуулна.	Улсын зохион	Арга хэмжээний тоо	0	1	<p>Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Мэдээллийн технологийн улсын олимпиад зохион байгуулах" ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Ажлын даалгаврын дагуу шууд худалдан авалтын хэлбэрээр гүйцэтгэгчийг сонгож, холбогдох тушаал болон гэрээг батлуулан, гэрээний дагуу 2025 оны 04 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд уг олимпиадыг амжилттай зохион байгуулахад оролцож, гэрээ дүгнэх актыг баталгаажуулан, холбогдох санхүүжилт олгогдсон.</p> <p>Мэдээллийн технологийн улсын олимпиад (Улсын программчлалын 33 дугаар олимпиад)-ыг 2025 оны 04 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд Монгол Улсын Боловсролын их сургууль дээр зохион байгуулсан. Уг олимпиадад нийт 7 сургуулийн 11 багийн 33 оюутан оролцон 2 өдрийн турш 6 бодлогыг шийдвэрлэх программ бичиж өрсөлдөж, онооны эрэмбээр алтан</p>	I-IV улирал	100

					медаль 1, мөнгөн медаль 2, хүрэл медаль 3, шагналт тусгай байр 2, шагналт байр 3-ыг тус тус шалгаруулсан.		
Зорилт 4. Хиймэл оюун, их өгөгдөл зэрэг дэвшилтэт технологид тулгуурлан нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдаасах, хиймэл оюун ухаанд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэхэд салбар хоорондын уялдааг хангах	Хүргүүлсэн баримт бичгийн тоо Арга хэмжээний тоо Судалгааны тоо Боловсруулсан баримт бичгийн тоо Системийн тоо	0 0 0 0 0	2 3 1 2 1		Хүргүүлсэн баримт бичгийн тоо 0 Арга хэмжээний тоо 2 Судалгааны тоо 1 Боловсруулсан баримт бичгийн тоо 1 Системийн тоо 0		
23. Арга хэмжээ 4.1. Хиймэл оюун, их өгөгдөл, блокчайн, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбоксын журмыг Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн журмын тоо	0	1		Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 6.1.6-д заасны дагуу "Хиймэл оюун, их өгөгдөл, блокчайн, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбокс орчны зохицуулалтын журам"-ын төслийг эхний байдлаар боловсруулсан.	II-III улирал	60
24. Арга хэмжээ 4.2. Их өгөгдөл, хиймэл оюуны үндэстний стратегийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1		Их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал болон дэлхийн цаашдын чиг хандлагын талаар судалж, 2025 оны 01 дүгээр сарын 17-оос 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хооронд төр, хувийн хэвшлийн байгууллага, банк, финтек, шинжлэх ухааны салбарын эрдэмтэн, судлаачид, үүрэн холбооны оператор болон их, дээд сургуулийн нийт 500 орчим төлөөлөлтэй 6 удаагийн уулзалтуудыг зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн, дүн шинжилгээ хийсний дунд уг стратегийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Их өгөгдөл, хиймэл оюуны	I-II улирал	80

					<p>үндэсний стратегийн төслийг хэлэлцүүлэх анхдугаар чуулганыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг чуулганд гадаадын болон дотоодын илтгэгч, панелист, төр, хувийн хэвшлийн 1000 орчим төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны чиглэлийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн.</p> <p>Мөн их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал болон дэлхийн цаашдын чиг хандлагын талаар судалж, Монгол Улсын хэмжээнд хиймэл оюуныг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар судалж стратегийн төслийг боловсруулахад шаардлагатай суурь судалгааг хийсэн.</p> <p>Дээрх суурь судалгаанд үндэслэн “Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги”-ийг төслийг 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан, стратегийн төслийн талаарх танилцуулгыг холбогдох арга хэмжээ, хэлэлцүүлгүүдэд зориулан тухай бүр бэлтгэсэн.</p> <p>Уг стратегийн төслийг Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан “Хиймэл оюуны бэлэн байдлын үнэлгээ”-ний тайлангийн нээлтийн арга хэмжээнд Инновацын бодлого зохицуулалтын газрын П.Мөнхбат “Их өгөгдөл, хиймэл оюуны стратеги”-ийн танилцуулж хэлэлцүүлж ажлын хэсгийн гишүүдээс саналуудыг авсан. Тус яамнаас 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр “Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай” 02/1117 дугаартай албан тоотыг их дээд сургууль, шинжлэх ухааны академи, Монголын санхүүгийн технологийн холбоо ГҮТББ, Монголын банкны холбоо ГҮТББ, Үүрэн холбооны оператор компаниудад хүргүүлж, нийт 3 удаагийн цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Стратегийн төслийг сайд Ц.Баатархүү, газрын дарга Д.Мөнхбат нар танилцуулсан хэлэлцүүлж,</p>	
--	--	--	--	--	--	--

					оролцогчдын асуултад хариулж, санал солилцсон. Цуврал хэлэлцүүлгийн явцад гаргасан санал зөвлөмжүүдийг стратегид тусган сайжруулалт хийж Засгийн газарт өргөн барихаар ажиллаж байна.		
25.	Арга хэмжээ 4.3. Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	0	1	<p>Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/172 дугаар тушаалаар байгуулагдсан Хиймэл оюун ухааны стратеги төлөвлөгөө боловсруулах, олон улсын дээд хэмжээний арга хэмжээ зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг 1 дүгээр сарын 22, 27, 02 дугаар сарын 05, 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулсан. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төслийг хэлэлцүүлэх анхдугаар чуулганыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг чуулганд гадаадын болон дотоодын илтгэгч, панелист, төр, хувийн хэвшлийн 1000 орчим төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны чиглэлийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Уг чуулганыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:</p> <p>Тус яамнаас 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр "Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай" 02/1117 дугаартай албан тоотыг Их дээд сургууль, Шинжлэх ухааны академи, Монголын санхүүгийн технологийн холбоо ГҮТББ, Монголын банкны холбоо ГҮТББ, Үүрэн холбооны оператор компаниудад хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийн төслийг эцэслэх цуврал хэлэлцүүлгийн эхний хэлэлцүүлгийг ШУА-ийн эрдэмтэн, их дээд сургуулийн багш, судлаач нарт, хоёрдугаар хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр арилжааны банк, финтекийн холбооны гишүүд, үүрэн холбооны оператор компаниудад, 3 дахь хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр стартап компаниудын дунд зохион байгуулсан. Төслийг сайд</p>	I улирал	100

					Ц.Баатархүү, газрын дарга Д.Мөнхбат нар танилцуулан хэлэлцүүлж, оролцогчдын асуултад хариулж, санал солилцсон.		
26.	Арга хэмжээ 4.4. Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгсэл, хүний нөөцийн тооцоо, судалгаа хийнэ.	Судалгааны тоо	0	1	<p>1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн A/51 дүгээр тушаалаар их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хэрэгжилтийг ханганд ажилласан. Үүний үр дүнд нийгмийн даатгалын мэдээллийн сан, нийгмийн халамжийн мэдээллийн сан, хүн амын өрхийн мэдээллийн сан, мал тооллогын мэдээллийн сан, бизнес регистрийн мэдээллийн сан зэрэг 5 өгөгдлийн сангийн мета өгөгдөл дээр боловсруулалт хийсэн.</p> <p>2. Мэдээллийн сан тус бүрээс 1 сая мөр өгөгдлийн регистрийн дугаарыг шифрлэлтийн арга ашиглан татан авч, хоорондын нийцтэй байдал, мэдээлэл боловсруулах хурд зэргийг C, Python, Go зэрэг 3 төрлийн программчлалын хэл дээр амжилттай туршсан. Мөн их өгөгдлийн сан үүсгэх дэд бүтцийг бэлдэх ажлын хүрээнд Үндэсний дата төв УТҮГ нь 500GB санах ой бүхий нөөцийг үүсгэсэн.</p> <p>3. Мэдээлэл хариуцагч байгууллагууд тодорхойлох боломжгүй болгосон өгөгдлийг төрийн мэдээлэл солилцооны систем (ХҮР)-ээр дамжуулах, өгөгдлийн агуулахад нийлүүлэх шийдлийг гаргаж, архитектур шийдлийн дагуу сервисийг хөгжүүлсэн.</p> <p>4. Өгөгдөл хувиргах хэрэгслийг суулгаж, тохируулах гарын авлага, хувиргасан өгөгдлийг ХҮР системээр дамжуулах зааврыг тус тус боловсруулсан.</p> <p>5. Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр “Их өгөгдлийн (big data) сан”-т үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлэх техникийн нөхцөл бүрдсэн. Харин их</p>	I улирал	100

						өгөгдлийн сан үүсгэхэд шаардлагатай техник хангамж болон программ хангамжийн зардал нь 7,7 тэрбум төгрөг болох тооцоо судалгаа гарсан бөгөөд санхүүжилтийг шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.		
27.	Арга хэмжээ 4.5. Хиймэл оюуны засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулах.	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	1		<p>Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Хиймэл оюун ухааны засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн хэвшилд шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулах" ЦХИХХЯ/20250203067 дугаартай үйлчилгээний тендер шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/83 дугаар тушаалаар байгуулсан.</p> <p>Тус үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн сайн тендер ирүүлсэн "Дижитал воркс" ХХК-ыг шалгаруулан мэдэгдэл хүргүүлж гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч компани явцын болон эцсийн тайлангаа ирүүлж гэрээний хугацаанд багтааж сайжруулалт хийлгэхээр ажиллаж байна.</p>	I-II улирал	90
28.	Арга хэмжээ 4.6. Хиймэл оюунд сууринсан "Виртуал багш" системийг хөгжүүлнэ.	Системийн тоо	0	1		Тайлант хугацаа болоогүй.	I-IV улирал	-
29.	Арга хэмжээ 4.7. Хиймэл оюуны хөгжүүлэлтийн төв байгуулах даалгавар боловсруулна.	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	1		<p>"Хиймэл оюун ухааны хөгжүүлэлтийн төв байгуулах ажлын даалгавар боловсруулах" ажлын даалгаврын дагуу "Эй ай ризирч" ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Y/03 дугаартай гэрээг байгуулж, тайланг авсан.</p> <p>Тайлангийн хүрээнд уг төв нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох "Алсын хараа 2050"-ын зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн стратегийн ач холбогдол бүхий санаачилга бөгөөд энэхүү төв нь</p>	I-III улирал	100

						шинжлэх ухаан, технологи, инновацийн тогтолцоог бэхжүүлж, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих, нийгмийн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, олон улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулах боломжтой. Мөн стратегийн ач холбогдол, эдийн засгийн боломжууд, нийгмийн үр ашиг, технологийн чадавхын хөгжил, сорилт бэрхшээл, олон улсын хамтын ажиллагаа, урт хугацааны өгөөж зэргийг боловсруулан гаргаж өгснөөс гадна зөвлөмж хэсэгт б шийдэл бөгөөд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг гаргаж ирүүлсэн.		
30	Арга хэмжээ 4.8. Өгөгдлийн хакатон зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	0	1	Tайлант хугацаа болоогүй.	I-III улирал	-	
31.	Арга хэмжээ 4.9. Хиймэл оюуны Улсын олимпиад зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	0	1	<p>“Хиймэл оюуны Улсын олимпиад зохион байгуулах” ЦХИХХЯ/20250603108 дугаартай үйлчилгээний Y/11 дугаартай гэрээг 2025 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн Монгол Улсын Их Сургуулийн Мэдээллийн Технологи, Электроникийн Сургуультай байгуулсан. Уг гэрээний хүрээнд www.kaggle.com платформыг ашиглан олимпиадыг хоёр үе шаттайгаар зохион байгуулсан бөгөөд нэгдүгээр шатыг 2025 оны 5 дугаар сарын 02-ноос 14-ний хооронд онлайнаар, хоёрдугаар шатыг 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдөр танхимаар тус тус явуулсан.</p> <p>Уг олимпиадад нийслэл, орон нутгаас нийт 272 сургач бүртгүүлэн оролцсоноос нэгдүгээр шатанд 91 сургач, хоёрдугаар шатанд 50 сургач тус тус хамрагдсан. Хоёрдугаар шатнаас шалгарсан 8 сургач Хиймэл оюуны олон улсын II олимпиадад Монгол Улсаа төлөөлөн оролцохоор тодорсон.</p>	I-IV улирал	100	
Зорилт 5. Мэдээллийн технологи, программ хангамжийн		Судалгааны тоо	0 0 0	2 2 2	Судалгааны тоо 0 Боловсруулсан баримт бичгийн тоо 0 Хүргүүлсэн журмын төслийн тоо 2			

		Үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны бизнесийг дэмжих	Боловсруулсан баримт бичгийн тоо Хүргүүлсэн журмын төслийн тоо Платформын тоо Арга хэмжээний тоо Эхлүүлсэн төслийн тоо	0 0 0	1 2 1	Платформын тоо 0 Арга хэмжээний тоо 0 Эхлүүлсэн төслийн тоо 0		
32.	Арга хэмжээ 5.1. Инновац, ёндөр технологи, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын санг байгуулах судалгаа хийх, экосистемийн замын зураглал боловсруулна.	Судалгааны тоо Боловсруулсан баримт бичгийн тоо	0 0	1 1	"Инновац, ёндөр технологи, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын санг байгуулах судалгаа хийх, экосистемийн замын зураглал боловсруулан батлуулсан.  Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/133 дугаар тушаалаар байгуулсан.		II улирал	40
33.	Арга хэмжээ 5.2. "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, виртуал бүсийн ажиллах журам"-ын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн журмын төслийн тоо	0	1	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.7-д заасны дагуу "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам"-ын төслийг боловсруулан, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зэвлэлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралд танилцуулан хэлэлцүүлсэн бөгөөд хурлын шийдвэрээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтсон.  Дээрх шийдвэрийн дагуу журмын төслийг Засгийн газрын тогтоолын төсөл, журмын танилцуулгын хамт боловсруулж, ЗГХЭГ, Шадар сайд нар, Засгийн газрын гишүүд болон Үндэсний хороод зэрэг нийт 22	I-II улирал	100	

						байгууллагад 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1009 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу 19 байгууллагаас ирсэн саналыг нэгтгэн журмын төслийг эцэслэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.		
34.	Арга хэмжээ 5.3. “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын үзүүлэх болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн журмын төслийн тоо	0	1	Mэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 13.4-т заасны дагуу “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг боловсруулан, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралд танилцуулан хэлэлцүүлсэн бөгөөд хурлын шийдвэрээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтсон.  Дээрх шийдвэрийн дагуу журмын төслийг Засгийн газрын тогтоолын төсөл, журмын танилцуулгын хамт боловсруулж, ЗГХЭГ, Шадар сайд нар, Засгийн газрын гишүүд болон Үндэсний хороод зэрэг нийт 22 байгууллагад 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1009 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу 19 байгууллагаас ирсэн саналыг нэгтгэн журмын төслийг эцэслэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	I-IV улирал	100	
35.	Арга хэмжээ 5.4. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн платформ хөгжүүлнэ.	Платформын тоо	0	1	Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/01 дугаар тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн платформыг хөгжүүлэх” ажлын даалгаврыг боловсруулан, батлуулсан.  Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/190 дугаар тушаалаар байгуулагдан 2025 оны 6 дугаар сарын 13-нд зарлахаар ажиллаж байна.	II-IV улирал	50	

36.	Арга хэмжээ 5.5. Дроны туршилтын төв байгуулах ажлыг эхлүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 209 дугаар тогтоол	100	<p>Газар зохион байгуулалт, геодези зураг эзүйн ерөнхий газраас 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр 1/381 албан тоотоор ирүүлсэн байршилтуудыг 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр 02/851 албан тоотоор Харилцаа холбооны зохицуулах хороонд радио давтамжийн харилцан нөлөөллийн хэмжилт дүгнэлт гаргуулахаар албан тоот хүргүүлсний дагуу дүгнэлт хэмжилтийн тайлан авсан. Тус байршилд нь газарзүй дэд бүтцийг судлахад Баянзүрх дүүргийн байршил нь намагтай, дэд бүтцээс 5км зйтай, харин Дархан-Уул аймгийн байршил нь Атарын 4 дүгээр аяны талбайтай давхцуулж түр хугацаанд ашиглах байршил гэдэг утгаар өгсөн нь уг туршилтын бүс байгуулахад шаардлага хангахгүй тул, нарийвчилсан шаардлагыг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр 02/239 дугаартай албан бичгийг ГЗБГЗ3Г-т хүргүүлсэн. Үүний дагуу дээрх байгууллагаас урьдчилсан байдлаар 4 байршилтуудын мэдээллийг авч, Иргэний нисэхийн ерөнхий газраас урьдчилсан дүгнэлт гаргуулан, боломжит байршилтуудыг албажуулж авахаар ГЗБГЗ3ЕГ-аас 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр 1/1672 албан тоот хүргүүлсэн.</p> <p>Мөн РТҮС хонхор дах станцын талбай дээр нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн түр туршилтын бүс байгуулахаар холбогдох зөвшөөрлүүд болох Иргэний нисэхийн ерөнхий газраас 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр 01/849 албан тоотоор холбогдох зөвшөөрлийг авч албан тоотын дагуу Зэвсэгт хүчний жанжин штабын харья Агаарын цэргийн командлалаас зөвшилцэхөөр албан тоот хүргүүлсэн. Мөн Хот байгуулалт хотын стандартын газарт албан тоот хүргүүлж 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 02/80 албан тоотоор хариуг авч Архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлуулах шаардлагын дагуу холбогдох материалыг бүрдүүлэн ажиллаж байна.</p>	I-IV улирал	80	
37.	Арга хэмжээ 5.6. МХХТ-ийн салбарын тоо	Хөтөлбөрийн тоо	0	1	"МХХТ-ийн салбарын бизнес эрхлэгч, гарааны бизнесүүдэд ээлтэй, хууль, эрхзүй, санхүүгийн	I-II улирал	40	

	бизнес эрхтэгч, гарааны бизнесүүдэд ээлтэй, хууль, эрхзүй, санхүүгийн тогтвортой орчныг бүрдүүлэх "Business friendly Mongolia" хөтөлбөр боловсруулна.				тогтвортой орчныг бүрдүүлэх "Business friendly Mongolia" хөтөлбөр боловсруулах" ажлын даалгаврыг боловсруулсан батлуулсан.  Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/1590 дугаар тушаалаар байгуулсан.		
38.	Арга хэмжээ 5.7. Өндөр хөгжилтэй орнуудын гарааны бизнес, хөрөнгө оруулалт, өндөр технологи, инновацын талаарх шинэ мэдлэг, мэдээлэл, нэү-хау импортлох, нутагшуулах" ЦХИХХЯ/202501030899 дугаартай тендер шалгаруулалтыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/112 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 05 дугаар сарын 01-ний өдөр цахим системд нийтлэн зарлаж, 05 дугаар сарын 23-ны өдөр нээсэн. Нэг оролцогчтой байсан боловч тухайн оролцогч шаардлага хангаагүй тул 05 дугаар сарын 29-ний өдөр дахин зарласан бөгөөд тендерийн 06 дугаар сарын 19-ний өдөр нээж, үнэлнэ.	Арга хэмжээний тоо	0	1	"Өндөр хөгжилтэй орнуудын гарааны бизнес, хөрөнгө оруулалт, өндөр технологи, инновацын талаарх шинэ мэдлэг, мэдээлэл, нэү-хау импортлох, нутагшуулах" ЦХИХХЯ/202501030899 дугаартай тендер шалгаруулалтыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/112 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 05 дугаар сарын 01-ний өдөр цахим системд нийтлэн зарлаж, 05 дугаар сарын 23-ны өдөр нээсэн. Нэг оролцогчтой байсан боловч тухайн оролцогч шаардлага хангаагүй тул 05 дугаар сарын 29-ний өдөр дахин зарласан бөгөөд тендерийн 06 дугаар сарын 19-ний өдөр нээж, үнэлнэ.	I-II улирал	70
39.	Арга хэмжээ 5.8. Гарааны бизнес, инновацын талаар мэдлэг, соёлыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	I-III улирал	-
40.	Арга хэмжээ 5.9. Монголын гарааны бизнесийн санхүүжилтийн хуртээмж судалгаа хийнэ.	Судалгааны тоо	0	1	"Монголын гарааны бизнесийн санхүүжилтийн хуртээмж судалгаа" ЦХИХХЯ/20250603106 дугаартай үйлчилгээний шууд худалдан авалтын ажлыг зохион байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 27-ны А/174 дугаартай гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай тушаал, 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр У/18 дугаартай гэрээг байгуулан ажиллаж байна.	I-III улирал	90

Зорилт 6. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх		Үнэлгээний хороонд ажилласан албан хаагчдын тоо  Дүүргэж төгссөн албан хаагчдын тоо	0 0	6 3	Үнэлгээний хороонд ажилласан албан хаагчдын тоо 3  Дүүргэж төгссөн албан хаагчдын тоо 2		
41.	Арга хэмжээ 6.1. Худалдан авах ажиллагааны сургалтад албан хаагчдыг хамрагдана.	Амжилттай төгсөгчдийн тоо	2	6	Худалдан авах ажиллагааны сургалтад 4 албан хаагч хамрагдаж, нийт 3 албан хаагч А3 сертификаттай авсан.	I-IV улирал	100
42.	Арга хэмжээ 6.2. Төрийн албаны сургууль Удирдлагын академийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдана.	Төгссөн албан хаагчдын тоо	0	3	Төрийн албаны сургууль Удирдлагын академийн Төрийн албанд томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад Б.Дэлгэрмаа болон С.Эрдэнэболд нар хамрагдан амжилттай төгссөн.	I-IV улирал	100
43.	Арга хэмжээ 6.3. Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдана.	Хамрагдсан албан хаагчдын тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	I-IV улирал	-
Зорилт 7. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.							

44.	Арга хэмжээ 7.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад санал өгнө.	Санал өгсөн эсэх	0	Тийм	Санал өгөх хугацаа болоогүй.	I-IV улирал	-
45.	Арга хэмжээ 7.2. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэнэ.	Шийдвэрлэлтийн дундаж хоногийг хугацаагаар	-	Шийдвэр лэлтийн дундаж хугацаа 17 хоног	Хуучнаар Боловсрол шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлсэн "Мон Икс 2024" инновацын хөтөлбөрийн хүрээнд иргэн С.Золбаяр нарын 9 иргэнээс ирсэн грантын санхүүжилтийг олгох талаар өргөдөлд хариу тайлбар боловсруулан 2024 оны 04 сарын 16-ны өдрийн 02/853 дугаар албан бичгийг иргэн С.Золбаяр нарын 9 иргэнд хүргүүлэв. Мөн тус гомдолтой холбоотой тайлбарыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 05 сарын 01-ний өдрийн 02/1032 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	I-IV улирал	100

#### ХОЁР. НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / Биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
1.	Үүрэг даалгавар 1. Монгол Улсын богино болон дунд хугацааны хөгжлийн баримт бичигт санал боловсруулна.	Санал өгсөн хуулийн болон санамж бичгийн төслийн тоо	-	2	1. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөнд инновац, гарцааны бизнес, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр санал боловсруулж, СБТГ-т өгсөн. Мөн түүнчлэн с хүргүүлсэн саналын хүрээнд ЗГХЭГ-ын холбогдох албан тушаалтнуудтай 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр уулзаж, уулзалтын хүрээнд хүргүүлсэн	01.15-12.10	100

					<p>арга хэмжээний талаар мэдээлэл өгч, харилцан ярилцсаны дүнд саналуудыг засч сайжруулан цахимаар хүргүүлсэн.</p> <p>2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөлд инновац, хиймэл оюун ухаан, гарааны бизнес зэрэг чиглэлээр оруулах арга хэмжээг шалгuur үзүүлэлтийн хамт боловсруулан СБТГ-т өгсөн.</p> <p>3. Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгуулахаар дор дурдсан арга хэмжээний саналыг холбогдох мэдээллийн хамт боловсруулан СБТГ-т өгсөн:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хиймэл оюуны үндэсний хэмжээний тогтолцоог бүрдүүлж, GPU кластер бүхий төв байгуулах;</li> <li>- Уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, зам, тээвэр, логистик, эрүүл мэнд, хөдөө аж ахуй болон бусад тэргүүлэх салбарт хиймэл оюун, их өгөгдөл зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх 100 туршилтын төслийг үе шаттай хэрэгжүүлэх;</li> <li>- Дэвшилтэт технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх сэндбокс байгуулах;</li> <li>- Мэдээллийн технологийн төрөлжсен төв байгуулах;</li> <li>- Нисгэгчгүй нисэх техөөрөмж (дрон)-ийн туршилтын бус байгуулах.</li> </ul> <p>4. Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 02 дугаар албан даалгаврын хүрээнд хиймэл оюун ухаан, өндөр технологи болон ногоон хөгжлийн чиглэлээр тусгуулах арга хэмжээний саналыг холбогдох мэдээллийн хамт боловсруулан СБТГ-т өгсөн.</p> <p>5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026-2028 оны хөрөнгө оруулалтын төсөлд санал болон 2026 оны</p>	
--	--	--	--	--	---	--

					төсвийн төсөлд санал боловсруулж, Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтэст өгсөн.		
2.	Үүрэг даалгавар 2. Олон улсын байгууллагатай хамтран ажиллана.	Санал хүргүүлсэн төслийн тоо	-	Тухай бүр	<p>1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж буй Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хөрөнгө оруулалтын стратеги боловсруулах судалгааны тайллангийн уулзалтыг зохион байгуулж, оролцсон. Уг уулзалтаар тайлланг сайжруулахтай холбоотой асуудлын талаар хэлэлцэж, явцын тайланд санал өгсөн.</p> <p>2. Японы хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай Техникийн хамтын ажиллагааны хүрээнд салбарын хууль эрх зүйн орчинг сайжруулах, хүний нөөцийн бодлого боловсруулах, гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэх, их өгөгдлийг бий болгох чиглэлүүдээр хамтран ажиллахаар салбарын өнөөгийн байдал, хийх ажлын талаарх мэдээллийг хүсэлтийн хамт боловсруулан, тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулан ЖАЙКА-д хүргүүлсэн.</p> <p>3. Нэгдсэн үндэстний байгууллагаас ирүүлсэн Үндэсний өгөгдлийн засаглалын тайлантай танилцаж, санал боловсруулан газрын даргад танилцуулсан.</p> <p>Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн гүйцэтгэсэн Үндэсний блокчейн хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх бэлэн байдлын үнэлгээний тайлантай танилцаж, санал боловсруулан газрын даргад танилцуулж хүргүүлсэн.</p>	01.15-12.10	100
3.	Үүрэг даалгавар 3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй 2022 онд байгуулсан Харилцан ойлголцлын Санамж бичгийн хүрээнд инновац үйлдвэрлэлийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор хамтарсан төсөл эхлүүлэх төлөвлөгөөг байгуулахаар төлөвлөгөөний төслийг айлын талтай эцэслэсэн, тус	Баталсан төлөвлөгөөн ий тоо	-	1	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй 2022 онд байгуулсан Харилцан ойлголцлын Санамж бичгийн хүрээнд инновац үйлдвэрлэлийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор хамтарсан төсөл эхлүүлэх төлөвлөгөөг байгуулахаар төлөвлөгөөний төслийг айлын талтай эцэслэсэн, тус	01.10-06.10	100

	бичгийн хүрээнд хамтран ажиллана.				төлөвлөгөөг хянуулахаар Гадаад харилцааны яам руу 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/179 дугаартай албан бичгийг хүргүүлсэн.  Үүний дагуу төсөл өхлүүлэх төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 03-нд байгуулсан. Тус төлөвлөгөөнд заасан ажлуудыг санхүүжүүлэх зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй Г/02 "Санхүүжилтийн гэрээ"-г 2025 оны 02 дугаар сарын 12-нд байгуулсан. Гадаад харилцааны яаманд гэрээг бүртгүүлэхээр гэрээний эх хувийг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст хүлээлгэн өгсэн.		
4.	Үүрэг даалгавар 4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/171 тушаалын дагуу байгуулагдсан Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үнэлгээ хийх дэд ажлын хэсгийн (Модуль 11) ажлын хэсэгт өөрт ноогдох үнэлгээ хийх хувьсагч болох "Цахим "хар зах" руу нэвтрэх (dark web)" бүлгийн судлах дэд статистикууд болох Dark web ашиглан террористууд виртуал хөрөнгөөр галт зэвсэг худалдан авах эрсдэлийн судалгааг хийж гүйцэтгэсэн.				Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ хийх дэд ажлын хэсгийн (Модуль 11) ажлын хэсэгт өөрт ноогдох үнэлгээ хийх хувьсагч болох "Цахим "хар зах" руу нэвтрэх (dark web)" бүлгийн судлах дэд статистикууд болох Dark web ашиглан террористууд виртуал хөрөнгөөр галт зэвсэг худалдан авах эрсдэлийн судалгааг хийж гүйцэтгэсэн.	01.15-12.10	100
5.	Үүрэг даалгавар 5. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Дархан-Уул аймагт "Цахим үйлчилгээний хөдөлгөөнт цэг, Цахим ур чадварын төвийг байгуулах" туршилтын төсөл хэрэгжүүлнэ.	Хэрэгжүүлсэн төслийн тоо	-	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, олон нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх "Strengthening Digital E-mongolia Services and Communities (DEMOSC)" төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран ажиллах үүрэг бухий Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг Дархан-Уул аймагт хэрэгжүүлж байгаа төслийн ажлын явц, санхүүжилтийн хуваарийн талаар мэдээлэл солилцох уулзалтуудыг 2025 оны 01, 02 дугаар саруудад зохион байгуулсан ба уулзалтаар	01.10-06.10	100

					Цахим ур чадварын төвийн бэлтгэл ажил, хөдөлгөөнд станцын машины техникийн үзүүлэлтийн талаар санал солилцон зарим асуудлыг шийдвэрлэж ажилласан. Энэхүү төслийн хүрээнд Дархан-Уул аймагт хэрэгжүүлж байгаа “Цахим үйлчилгээний хөдөлгөөнт цэг, Цахим ур чадварын төвийг байгуулах” ажлын явцын мэдээллийг 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. Төсөл амжилттай хэрэгжиж 2025 оны 06 дугаар сард нээлтээ хийхээр ажиллаж байна.		
6.	Үүрэг даалгавар 6. Хиймэл оюуны чиглэлийн судалгаа хийнэ.	Судалгааны тоо	-	2	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Хиймэл оюуны бэлэн байдлын үнэлгээ”-ний аргачлалаар Монгол Улсын хиймэл оюуны өнөөгийн бэлэн байдлын үнэлгээг хийсэн бөгөөд үнэлгээгээр Монгол Улсын “З оноо” буюу “Системчлэгдэх үе шат”-д байрлаж байна. Мөн уг байгууллагатай хамтран олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн “Ирээдүйг урьдчилан төсөөлөх судалгааны аргачлал” (Framework Foresight Methodology, University of Houston)-ын дагуу “Хиймэл оюуны хэтийн төлөвийн судалгаа”-г хийж, хиймэл оюуны хөгжүүлэхэд тодорхой бус буй асуудлыг тодорхойлсон.	01.10-06.10	100

Төлөвлөгөөг үнэлсэн:

Төрийн нарийн бичгийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....

Төсвийн шууд захирагч

П.АЛТАН-ОД

..... (огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Төрийн захиргааны удирдлагын газрын даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....

Нэгжийн дарга

Д.БАТБИЛЭГ

..... (огноо)

Тайлагнасан:

Инновациын бодлого зохицуулалтын газрын  
даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч



Нэгжийн дарга

П.МОНХБАТ

..... 2008/05/06 ..... (огноо)